



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ДЭЛГЭРХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 09 сарын 30 өдөр

Дугаар 4/98

Дэлгэрхаан сум

**Газар эзэмших эрхийн гэрчилгээг
шилжүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Холбогдох хууль тогтоомжийн дагуу газар эзэмшүүлэх эрхийн гэрчилгээгээ шилжүүлэх хүсэлт гаргасан иргэн Ю.Эрдэнэтуяа /ХА50120501/-н амралтын газрын зориулалттай 2500 м2 газрыг иргэн Г.Амгалан /ХК35041614/-д 44 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмших эрхийн гэрчилгээг шилжүүлэн авсан иргэнтэй гэрээ байгуулан, биелэлтэд байнгын хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Ч.Батзориг)-т үүрэг болгосугай.

3. Газар эзэмших гэрээнд тусгагдсан зориулалт, нөхцөлийн дагуу газраа эзэмшин, гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж, гэрээнд заасан нөхцөл болзлыг биелүүлж ажиллахыг (Г.Амгалан)-д даалгасугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2008 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн 66 дугаар захирамжийн иргэн (Ю.Эрдэнэтуяа)-д холбогдох хэсгийг хүчингүйд тооцсугай.

ДАРГА

Э.ТӨГӨЛДӨР

